

ФИЛИППИН:

МАРИНЭЛ САМУУК ЮБАЛДО

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ ДАВАН ТУУЛАХЫН ТӨЛӨӨ

ЭРХИЙНХЭЭ
ТӨЛӨӨ
БИЧИЦГЭЭЭ

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШЛ



МАРИНЭЛ САМУУК ЮБАЛДО

ФИЛИППИН

16 настай Маринэл Самуук Юбалдо 2013 оны 11-р сарын 13-нд болсон үхлийн аюулт Еланда хар салхинаас амьд гарсан юм. Уг хар салхины улмаас түүний амьдардаг Самар арлын тосгон сүйдэж, зөвхөн Филиппинд гэхэд 6000 гаруй хүн нас барж, олон сая хүн орон гэргүй болсон юм.

6 жилийн дараа Маринэл нийгмийн ажилтнаар суралцан төгсөж, байгальд хайртай, олонд танигдсан залуу идэвхтэн болж, чөлөөт цагаа нутгийнхаа иргэдийн эрхийн төлөө кампанит ажил өрнүүлэхэд зориулдаг болсон.

2018 оны 9 дүгээр сард Маринэл ашигт малтмалын үйлдвэрүүд уур амьсгалын өөрчлөлтөд хэрхэн нөлөөлж буй талаар ярихаар Нью Йоркыг зорьж, чуулганд оролцогчдод "Би зөвхөн . . . уур амьсгалын талаарх статистик ярих гэж ирээгүй, энд би эмзэг, гадуурхагдсан бүлгийг төлөөлж дуу хоолойгоо сонгохоор ирсэн." хэмээн өгүүлсэн юм.

Хар салхины улмаас орон гэргүй болсон олон мянган хүнд хүрэлцээтэй хоол хүнс, ундны ус, орон байр, тог цахилгаан, ариун цэврийн байгууламж хэрэгтэй байна. Гэвч Филиппиний засгийн газар энэ асуудлаар шаардлагатай арга хэмжээ авалгүй, тэднийг эрүүл ахуйн шаардлага хангаагүй, амьжиргаагаа залгуулах орлогын эх үүсвэр хомс орчин нөхцөлд амьдрахад хүргэж байна.

Харин Маринэл дэлхийн засгийн газруудаас, түүний төрөлх тосгоны иргэд болон тэдэнтэй ижил нөхцөлд байгаа хүмүүст үзүүлж буй уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагаврыг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг шаардан тэмцэж байгаа юм.

ФИЛИППИНИЙ ЗАСГИЙН ГАЗАРТ ХАНДАН ЗАХИДАЛ БИЧИЦГЭЭ.

Зүүн Самар, Матаринаогийн оршин суугчдын зохистой орчин нөхцөлд амьдрах эрхийг нь баталгаажуулах бүхнийг хийхийг уриалцаагай.

President of the Philippines
Malacañang Complex, J.P. Laurel Street, San Miguel, Manila 1005, Philippines

Email:
pcc@malacanang.gov.ph

Twitter: @pcoogov

Facebook:
https://www.facebook.com/pcoogov/

Salutation: Dear President

МАРИНЭЛД ДЭМЖИЖ БАЙГААГАА ИЛЭРХИЙЛСЭН ЗАХИДАЛ ЗУРВАС ИЛГЭЭГЭЭРЭЙ.

Marinel Ulbaldo,
C/O Amnesty International,
6-C Perseveranda Townhomes
II,
Maningning Street,
Sikatuna Village,
Quezon City,
1101
Philippines

**ЗАХИДАЛ БИЧИЖ
ӨӨРЧЛӨЛТ ХИЙЦГЭЭ**

December 2019
Index: ASA 35/0751/2019 English
Images: cover: © Michael Nagle/
Greenpeace (Main image), © DFID (CC)
Back page: © Lawrence Rui (CC)

